



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/638

Ховд

Гадаадын иргэн харьяатын баруун бүсийн
газрын ажилтнуудын орон сууцны дэмжлэг /Булган сум/-н
ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Эрдэнийн шим” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Гадаадын иргэн харьяатын баруун бүсийн газрын ажилтнуудын орон сууцны дэмжлэг /Булган сум/-н ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Н.Цацралцэцэг

- Мэргэжлийн хяналтын газрын
эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

Д.Нямтулга

- Мэргэжлийн хяналтын газрын барилгын
техникийн хяналтын улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

З.Өмиртай

- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын Барилга, хот байгуулалтын
хэлтсийн дарга

А.Хуанбай

- Гадаадын иргэн, харьяатын газрын
Баруун бүс дахь газрын дарга

- Ж.Дамдинбазар - Булган сумын Засаг дарга
- Ц.Цолмонбаатар - Стандарт хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн
- Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
- С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга
- С.Бямбасүрэн - Барилгын зураг төслийн "Алтайн газрын хүч" ХХК-ийн захирал
- Б.Амарболд - "Эрдэнийн шим" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. "Эрдэнийн шим" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Дээрх ажилтай холбогдолтой гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН